



Сурагчийн зан авир

Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Зан авир

Сургууль нь хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хүүхэд сургуульдаа сэтгэл ханамжтайгаар сурах орчныг бүрдүүлэхийг эрмэлзэж ажилладаг. Сурагчийн зөв төлөв байдлыг дэмжих нь тэдний сурлагын амжилт, сайн сайхан байдалд сайнаар нөлөөлдөг ба мөн сурагчийн оролцоог идэвхижүүлэн, нэмэгдүүлэхэд нэн чухал байдаг. Сургууль нь хамтын ажиллагаа, дэмжлэг мөн нягт холбоо бүхий бүгдийг тэгш хамруулсан сургалтын орчинг бүрдүүлэхийг зорьж ажилладаг. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчид мөн сурган хүмүүжүүлэгчид болон сургуулийн ажилтнуудын хувьд ямар утгатай талаар [Сургуулийн Хүрээлэлд Баримтлах Дүрэм](#)-д заасан байдаг.

Сурагчийн Зан Авирын талаарх Бодлого

Манай Сурагчийн Зан Авирын талаарх Бодлого ([Student Behaviour Strategy](#)) нь сурагч бүрийг таньж, үнэлэн, халамжилсан орчинтой, мөн бүгдийг тэгш хамруулсан боловсролын системийг бүрдүүлэх зорилготой ба мөн сурагч бүр өөрсдийн бүрэн чадавхаа дайчлан суралцахад нь тусалдаг. Сурагч аюулгүй орчинд, тусламж дэмжлэг байгааг мэдэрсэн үедээ сургуультайгаа илүү холбоотой байж, суралцах үйл ажиллагаанд идэвхитэй оролцох хандлагатай байдгийг бид мэднэ.

Эерэг, хүндэтгэлтэй сурах орчин нь сурагчийн сайн сайхан байдал, оролцоо мөн сурлагын амжилтанд сайнаар нөлөөлдөг. Энэхүү бодлого нь урьдчилан сэргийлсэн, эерэг, сурагч-төвтэй, мөн сургууль-гэр бүл-хүрээлэл гэсэн хандлага бүхий тууштай байдлыг чухалчилсан арга барилыг дэмждэг. Бүх сурагчдын хэрэгцээг "Тасралтгүй Анхаарал" ([Care Continuum](#))-н хүрээнд хангах болно.

Сурагчдын Зан Авирын Дүрэм

Сурагчдын Зан Авирын Дүрэмд ([Behaviour Code for Students](#)) нь NSW мужийн бүх улсын сургуулиудад баримтлавал зохих зохистой зан авируудыг заасан байдаг. Таны хүүхдийн сургууль нь мөн адил өөрийн сургууль дээр баримтлах ёстой зохистой зан авирын дүрмийг боловсруулах болно. Сургуулийн ажилтнууд нь зохистой зан авирын талаар таны хүүхдэд зааж сурган, сануулж байх болно.

Асуудал бүхий зан авирууд

Хүүхдүүд болон өсвөр насныхан үе үе хэцүү зан авир гаргах нь тэдний өсөлт хөгжлийн нэг хэсэг бөгөөд хэвийн үзэгдэл юм. Магадгүй таны хүүхэд бусдын зан авирын нөлөөлөлд автсан эсвэл түүний зан авир бусдад нөлөөлсөн байж болох юм. Нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб хуудасны [хэрвээ таны хүүхэд сургууль дээрээ зан авирын асуудал гаргасан тухайгаа танд мэдэгдвэл яах тухай](#) хэсгээс авна уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл

Хэрвээ та [зан авирыг дэмжих](#) талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, эсвэл танд хүүхдийнхээ зан авирт санаа зовнисон асуудал байвал сургуультай холбогдоно уу.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.